

## Баярын үеэр гэртээ аюулгүй байдлыг хангах

2022 оны 12 сар



Зураг 1: Дэлхийн өнцөг булан бүрт баяр тэмдэглэдэг

Их Дүйчин өдөр, Боксын өдөр, Зул сар, Гита Жаянти, Ханнука, Кванзаа, Шинэ жил, Омисака зэрэг нь оны төгсгөлд тэмдэглэгддэг баярууд юм. Ихэнхдээ ажилчид баяраар амралтаа авч гэр бүлтэйгээ өнгөрүүлдэг. Баяраар гэр бүл, найз нөхөд бэлэг солилцох нь ч бий.

Баярын өдрүүд ойртох тусам бид бэлэг худалдаж авах, хоол хийх, цэвэрлэгээ, чимэглэл хийх зэрэг бэлтгэл ажилтай завгүй болдог. Гэр бүл, найз нөхөд, орон байрны аюулгүй байдлыг баярын өдрүүдийн сэтгэл хөдлөлөөс хойгуур тавихгүй байх нь чухал юм.

Баярын өдрүүдэд орон байрны галын эрсдэл нэмэгддэг

Үүнийг ийм бүү болго!



## Та мэдэх үү?

- Галаас хамгаалах үндэсний нийгэмлэгийн тайлангаас харахад жил бүр баярын чимэглэлүүдээс үүдэлтэй орон байрны гал 770-аас илүүтэйгээр бүртгэгддэг байна.
- Гэрт зассан баярын гацуур модонд үүссэн галуудын бараг тал нь цахилгааны утас, гэрэлтүүлгийн хэрэгсэлтэй холбоотой байна. Баярын гацуур модонд гарсан галын 20% нь чимэглэлийн гэрлээс үүдэлтэй байна.

(ref. <https://www.nfpa.org/Public-Education/Fire-causes-and-risks/Seasonal-fire-causes/Winter-holidays>)

- Лаа ашигладаг баярын уламжлалууд байдаг. Лаанаас үүдэлтэй гал 12 болон 1-р саруудад их гардаг ба эдгээр саруудад 11%-ыг эзэлдэг.
- Зөвхөн тухайн үедээ л ашигладаг баярын чимэглэлүүд байдаг. Уг чимэглэлүүдийн нөхцөл байдал хадгалалтын үед муудах нь бий.
- Гэрлэн чимэглэлүүдийг тогтоож суурилуулахад олон тооны цахилгааны утас, залгуур, уртасгагч шаарддаг. Уртасгагч утас нь цахилгааны аюулаас гадна бүдрэх эрсдэлийг үүсгэдэг.
- Сальют нь баяр тэмдэглэх үйл явцын нэгээхэн хэсэг ба үүнийг маш болгоомжтой ашиглахгүй бол аюултай.

## Та юу хийж болох вэ?

- Гадна эсвэл дотно орчинд зориулагдсан гэрэл ашиглах
- Баярын чимэглэлүүдэд ашиглах утаснуудыг нэг бүрчлэн шалгах. Нэг тэжээлийн эх үүсвэрт олон залгуур залгахаас зайлсхий. Гэмтсэн утас, суларсан электрон ламп байгаа бол солих хэрэгтэй
- Чимэглэлдээ лаа ашиглах бол маш болгоомжтой хандаарай. Баттерей тэжээлтэй лаа болзошгүй галын эх үүсвэрээс сэргийлнэ.
- Баярын гацуураа өдөр бүр услаарай. Халууны эх үүсвэртэй хэт ойр байгаа мод өвлийн 4-н галын нэг шалтгаан болдог
- Өрөөнөөс гарах эсвэл унтахаасаа өмнө асаасан лаа болон чимэглэлийн бүх гэрлээ унтрааж байгаарай
- Хэрэв та эсвэл танай хөрш сальют ашиглах бол гал гарч болзошгүй зүйлсийг нягталж галын хор, усны хоолойн бэлэн байдлыг шалгаарай

**Баярын өдрүүдийн хамгийн том бэлэг бол аюулгүй байдал!**